



Худалдааны танхимууд Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулинд тавьсан хоригийг УИХ хүлээн авахыг уриалж байна.

УЛААНБААТАР, Монгол улс – Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийг 2023 оны 1-р сарын 18-ны өдөр Монгол улсын засгийн газар УИХ-д өргөн барьсан билээ. Тус хуулийг дагалдуулан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-ын чуулганаар нэгдүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталсан юм.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай энэхүү хууль нь Монгол улсын Үндсэн хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Хүний эрхийн тухай олон улсын түгээмэл тунхаглалууд, конвенцууд болон хүний үг хэлэх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг ноцтойгоор зөрчиж, Монгол улсын нэр хүндийг олон улсад унагаах, гадаадын хөрөнгө оруулалтыг үргээх өндөр эрсдэлтэй явдал боллоо гэж Монгол дахь Америкийн Худалдааны Танхим, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Европ Монголын хамтарсан Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, болон Монгол дахь Британийн Худалдаа Бизнесийн Нийгэмлэгийн зүгээс үзэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2023 оны 1-р сарын 30-нд Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль, түүнийг дагалдах 4 хуульд бүхэлд нь хориг тавьсан явдлыг бид ихэд сайшаан хүлээн авсан билээ.

Тиймээс бид санал нэгтгэйгээр дараах үндэслэлүүдээр уг хуулинд тавьсан хоригийг УИХ хүлээн авах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. Хууль тогтоомжийн тухай хууль болон уих-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг зөрчиж баталсан.
2. Хэт өргөн хүрээний томьёо ашигласнаар уг хуулийг хэтрүүлэн хэрэглэх өндөр эрсдэлийг бий болгосон.
3. Иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрхэд шууд халдсан.
4. Төрийн эрх баригч хүссэн цагтаа мэдээллийн сүлжээг хязгаарлах, хянах эрх мэдлийг хуулиар баталгаажуулсан.
5. Хүний эрхийг хамгаалах бус шүүхийн оролцоогүйгээр хязгаарлах нөхцлийг бүрдүүлж, хууль тогтоомжийн давхардал үүсгэсэн.
6. Монгол улсын нэр хүндийг олон улсад унагаах, гадаадын хөрөнгө оруулалтыг үргээх өндөр эрсдэлтэй.

Энэхүү хуулийг баталсан өдрөөс эхлэн Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын нэр хүнд бүхий компаниуд Монгол улс цаашид хүний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг ийнхүү хязгаарлах аваас Монгол улс дахь үйл ажиллагаагаа зогсоож, зах зээлээс гарахаас аргагүй болно гэдгээ илэрхийлээд байна.

Эцэст нь бидний зүгээс эдгээр хуулиудад бүхэлд нь тавьсан хоригийг УИХ-ын эрхэм гишүүд хүлээн авахыг уриалж байна. Ингэснээр олон нийтийн бухимдлыг тайлж, энэхүү хуулийг зохих хууль, журмын дагуу олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцогч талуудын саналыг тусган шинэчлэн батлах боломжтой гэж үзэж байна.